Журмын 3б хавсралт

/ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗАР/

"НИЙСЛЭЛИЙН 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ" ДУНД ХУГАЦААНЫ ТӨЛӨВЛӨЛТИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

2023.01.18

Улаанбаатар хот

| № | | Зорилт/Үйл ажиллагаа | Зорилт хэрэгжүүлэх Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Эх үүсвэр | Нийт хөрөнгийн хэмжээ | Суурь түвшин | Зорилтот түвшин үр дүнгийн үзүүлэлт | | | Хэрэгжилтийн явц | Хэрэгжилт хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Төсөв (сая.төг) | Төсвийн гүйцэтгэл (сая.төг) | | |
| 1. | 1.1 | 8.1. Монгол Улсын үндэсний түвшний хөгжлийн бодлоготой нийслэлийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийг уялдуулж, дагуул, хаяа хот, тосгодын хөгжлийг эрчимжүүлж, хотын төвлөрлийг сааруулах бодлогыг боловсруулна. | 8.1.1. "Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл", "Бүсийн хөгжлийн хөтөлбөр"-ийн төсөлд нийслэлийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийг уялдуулсан байна. | 2021 2025 | | | - | 2 | - | - | "Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл"-ийн судалгааны багтай 3 удаагийн уулзалт зохион байгуулж, уулзалтаас гарсан шийдвэрийн дагуу Улаанбаатар хотын хэмжээнд хийгдсэн хүн ам, нийгэм, эдийн засгийн төлөвлөлтийн тооцоо, таамаглалыг Барилгын хөгжлийн төвд хүргүүлж, тус газраас Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл боловсруулах ажлын хүрээнд хийгдсэн 2040 он хүртэл хэрэгжүүлэхээр төлөвлөж буй уул уурхай, зам тээвэр, үйлдвэр, эрчим хүчний мега төслүүдийн хүрээнд шууд болон шууд бусаар нэмэгдэж болох ажлын байр, түүнийг даган нэмэгдэх хүн амын тоо зэрэг хэтийн тооцоололтой холбоотой мэдээллийг авч ажлын уялдааг ханган ажиллав.<br>Нийслэлийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 01/1030 дугаартай "Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл" боловсруулах ажлын явц, үе | 100 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | шатны тайлан мэдээллийг ирүүлэх тухай албан бичгийг Барилга, хот байгуулалтын Сайдад ажлын явц, үе шатны тайлантай танилцаж санал өгөх тухай 2022 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 01/02/3581 дугаартай албан бичгийг “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-т хүргүүлсэн. Тус хүсэлтийн дагуу 2022 оны 10 дугаар сарын 21-ний өдөр Барилгын хөгжлийн төв, “Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-ын албан хаагчид хамтран хэлэлцүүлэг хийж “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийн төлөвлөлтийн шийдэлд тусгуулах санал өгсөн. | |
| | 1.2 | | 8.1.2. “Шинэ Зуунмод”, “Майдар” шинэ дагуул хотын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хилийн цэсийг өөрчлөх ажлыг холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран зохион байгуулсан байна. | 2021 2025 | | | 5 | 100 | - | - | Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж Улсын Их хуралд өргөн барихаар ажиллаж байна. Тус хөгжлийн ерөнхий төлөвлөгөө Улсын Их хурлаар батлагдсаны дараагаар ерөнхий төлөвлөгөөнд үндэслэн “Шинэ Зуун мод”, “Майдар” шинэ дагуул хотын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хилийн цэст өөрчлөлт оруулах саналыг эцэслэн хэлэлцүүлэхээр бэлтгэж байна. | 70 |
| | 1.3 | | 8.1.3. Төв аймагтай хамтран ажиллах эдийн засгийн болон нийгмийн хөгжлийн чиглэлийг тодорхойлж, хамтын ажиллагааг нэмэгдүүлсэн байна. | 2022 2025 | | | - | 1 | - | - | Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд “Шинэ Зуунмод”, “Майдар” дагуул хотуудын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хилийн цэсийг өөрчлөх ажлыг 2022 оноос холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран зохион байгуулахаар тусгагдсан. Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/595 дугаар захирамжаар үүрэг бүхий ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх Дэд ажлын хэсэг | 70 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | байгуулагдсан. “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ын төслийг боловсруулах ажлын хүрээнд Төв аймагтай хүн ам зүй, нийгэм эдийн засаг, тэргүүлэх чиглэлийг тодорхойлох ажил хийгдэж байна. | |
| | 1.4 | | 8.1.4. Богд уулыг тойрсон “Хөгжлийн алтан тойрог” төсөл, Улаанбаатар хотын дагуул хотуудыг түшиглэн ачаа тээврийн логистик төв байгуулах техник, эдийн засгийн үндэслэл, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулсан байна. | 2021 2025 | | 500,0 | - | 3 | - | - | Хөрөнгө оруулалтын ажил шийдэгдээгүйн улмаас тус ажил хийгдэх нөхцөл бүрдээгүй байна.<br>**Тайлбар:** Богдхан уулыг тойрсон “Хөгжлийн алтан тойрог” байгуулах ТЭЗҮ боловсруулах ажлыг Нийслэлийн 2022 оны төсөвт тусгагдсан “Шинээр баригдах барилга байгууламж, авто зам, инженерийн шугам сүлжээний зураг төсөв, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, ТЭЗҮ, мастер төлөвлөгөө, зөвлөх үйлчилгээ” боловсруулах хөрөнгөөс шийдвэрлэх саналыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст 2022 оны 02/325 дугаартай албан бичгээр хүргүүлсэн болович хөрөнгийн эх үүсвэр шийдвэрлэгдээгүй. Нийслэлийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд тусгуулах саналыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлсэн. | 30 |
| | | | 8.1.5. Улаанбаатар хотын дагуул, хаяа хот, тосгодын хөгжлийн төлөвлөлтийн баримт бичгүүдийг боловсруулж дуусгана. | 2022 2025 | | | 11 | 12 | - | - | Хөрөнгө оруулалтын ажил шийдэгдээгүйн улмаас тус ажил хийгдэх нөхцөл бүрдээгүй байна.<br>**Тайлбар:** Улаанбаатар хотын Жаргалант тосгон, 361-ын гарам тосгон, Рашаант тосгоны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлыг Нийслэлийн 2022 оны төсөвт тусгагдсан “Шинээр баригдах барилга байгууламж, авто зам, инженерийн шугам сүлжээний зураг төсөв, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, ТЭЗҮ, мастер төлөвлөгөө, зөвлөх | 30 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | үйлчилгээ" боловсруулах хөрөнгөөс шийдвэрлэх саналыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст 2022 оны 02/325 дугаартай албан бичгээр хүргүүлсэн боловч хөрөнгийн эх үүсвэр шийдвэрлэгдээгүй. Нийслэлийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд тусгуулах саналыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлсэн. | |
| | 1.5 | | 8.1.6. "Барилгын материалын бөөний худалдааны төв"-ийн техник, эдийн засгийн үндэслэл, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг батлуулж, ажлыг эхлүүлсэн байна. | 2022 2025 | | 413,0 | - | 1 | - | - | Хөрөнгө оруулалтын ажил шийдэгдээгүйн улмаас тус ажил хийгдэх нөхцөл бүрдээгүй байна.<br>**Тайлбар:** "Барилгын материалын бөөний худалдааны төв"-ийн техник, эдийн засгийн үндэслэл, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлыг Нийслэлийн 2022 оны төсөвт тусгагдсан "Шинээр баригдах барилга байгууламж, авто зам, инженерийн шугам сүлжээний зураг төсөв, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, ТЭЗҮ, мастер төлөвлөгөө, зөвлөх үйлчилгээ" боловсруулах хөрөнгөөс шийдвэрлэх саналыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст 2022 оны 02/325 дугаартай албан бичгээр хүргүүлсэн боловч хөрөнгийн эх үүсвэр шийдвэрлэгдээгүй. Нийслэлийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд тусгуулах саналыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлсэн. | 30 |
| | 1.6 | | 8.1.7. Улаанбаатар хотод сөрөг нөлөө үзүүлж байгаа үйлдвэр, аж ахуйн | 2022 2025 | | 120,0 | - | 1 | - | - | Хөрөнгө оруулалтын ажил шийдэгдээгүйн улмаас тус ажил хийгдэх нөхцөл бүрдээгүй байна. | 30 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | нэгжийг хотоос шилжүүлэх бодлого боловсруулж, хэрэгжүүлж эхэлсэн байна. | | | | | | | | **Тайлбар:** Улаанбаатар хотод сөрөг нөлөө үзүүлж байгаа үйлдвэр, аж ахуйн нэгжийг хотоос шилжүүлэх бодлого боловсруулах ажлыг Нийслэлийн 2022 оны төсөвт тусгагдсан "Шинээр баригдах барилга байгууламж, авто зам, инженерийн шугам сүлжээний зураг төсөв, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, ТЭЗҮ, мастер төлөвлөгөө, зөвлөх үйлчилгээ" боловсруулах хөрөнгөөс шийдвэрлэх саналыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст 2022 оны 02/325 дугаартай албан бичгээр хүргүүлсэн боловч хөрөнгийн эх үүсвэр шийдвэрлэгдээгүй. Нийслэлийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд тусгуулах саналыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлсэн. | |
| | 1.7 | | 8.1.8. Зарим их, дээд сургуулиудыг мэргэжлийн чиглэл, салбараар төрөлжүүлж, дагуул хотууд болон бусад аймгуудад шилжүүлэх асуудлыг шийдвэрлүүлсэн байна. | 2022 2025 | | | - | 1 | 937.1 | 463.7 | Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд Дагуул хот, тосгодыг хөгжүүлэх, Улаанбаатар хотын төвлөрлийг задлах зорилгоор зарим их, дээд сургуулиудыг мэргэжлийн чиглэл, салбараар нь төрөлжүүлж дагуул хот, тосгод руу нүүлгэн шилжүүлэх бодлого тусгагдсан. Тус хөгжлийн ерөнхий төлөвлөгөө Улсын Их хурлаар батлагдсанаар Их, дээд сургуулиудыг дагуул хотуудад шилжүүлэх бодлого хэрэгжиж эхэлнэ. Тухайлбал:<br>- Налайх хотод: ШУТИС-ын, Мэдээлэл технологийн салбар болон барилга, барилын материалын сургууль<br>- Багануур хотод: ШУТИС-ын Уул уурхайн салбар сургуулийн оюутны хотхон , | 70 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | - Багахангай хотод: Батлан хамгаалах, Хууль сахиулах их сургуулийн оюутны хотхон,<br>- Аргалант-Эмээлт хотод: Биеийн тамир спортын чиглэлийн их сургуулийн хотхон,<br>- Майдар хотод: Аялал жуулчлал, кино урлагийн дээд сургуулийн оюутны хотхон,<br>- 361-ын гарам тосгонд: Хөдөө аж ахуйн их сургуулийн оюутны хотхон. | |
| 2. | 2.1 | 9.1. Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулна. | 9.1.1. Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагалдан гарах зураг төсөл, баримт бичгийг боловсруулж, хэрэгжүүлж эхэлсэн байна. | 2021<br>2025 | | | 0 | 2 | - | - | - Засгийн газрын 2022 оны 99 дүгээр тогтоолоор Хүй долоо худаг дахь "Монгол наадам үндэсний спорт цогцолборын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө" батлагдсан.<br>- Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/524 дүгээр захирамжийн дагуу Улаанбаатар хотыг нэг төвт хотоос олон төвт хотын тогтолцоонд шилжүүлэх ажлын хүрээнд шинээр 3 дэд төв, 7 олон нийтийн төвийн техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын төсөл боловсруулах ажлын эцсийн тайланг хүлээн авч Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн 2022 оны 14 дүгээр хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжигдсэн бөгөөд Магадлалын нэгдсэн дүгнэлт хийлгэх, Барилга, хот байгуулалтын яамны Шинжлэх ухаан техник технологийн хурлаар хэлэлцүүлэх хүсэлтийг Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлсэн. Үүнд:<br>**Дэд төв:** "Амгалан", "Шинэ төв", "Сонсголон" дэд төвийн техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын төсөл;<br>**Олон нийтийн төв:** "Нисэх", "Тахилт", "Дарь-Эх", "Монель", "Бичил", "Ургах наран", "Хайлааст" олон нийтийн төвийн | 90 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын төсөл,<br>Дээрх ТЭЗҮ, барилгажилтын төсөл хийгдсэнээр иргэд, олон нийтэд үзүүлэх төрийн болон нийгмийн үйлчилгээний тэгш хүртээмж, орон сууцны хангамж нэмэгдэх, авто замын түгжрэлийг бууруулах зэрэг ач холбогдолтой юм.<br>- Улаанбаатар хотын төлөвлөлтийн Баруун-I бүсийн 23 дугаар нэгж хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, Багахангай дүүргийн үйлдвэрлэл, технологийн паркийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын төсөл боловсруулах ажилд Барилга хот байгуулалтын Сайдын тушаалаар магадлал хийх орон тооны бус экспертүүд томилогдон Магадлалын нэгдсэн дүгнэлт хийгдэж, Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн 2022 оны 14 дүгээр хуралдаанаар хэлэлцүүлж дэмжигдсэн.<br>- Улаанбаатар хотын инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөөний эхний тайланг Мэргэжлийн зөвлөлийн 2021 оны 10 дугаар хурал, дундын тайланг Мэргэжлийн зөвлөлийн 2022 оны 19 дүгээр хурлаар хэлэлцүүлэн дэмжигдсэн. Барилгын хөгжлийн төвийн захирлын тушаалаар томилогдсон Улсын 4 экспертүүдээр хянагдаж магадлалын нэгдсэн дүгнэлт хийгдсэн. Эцсийн тайланг хянан, холбогдох байгууллагуудаас санал авч тусган мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн.<br>- Нийслэлийн ногоон бүс /зуслан/-ийн 22 амны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний тодотгол боловсруулах | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | ажлын эхлэлийн тайланг Мэргэжлийн зөвлөлийн 2022 оны 39 дүгээр хурлаар хэлэлцүүлж хүлээн авсан.<br>- Эмээлт эко аж үйлдвэрийн паркийн техник, эдийн засгийн үндэслэл, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын эхлэлийн тайланг Мэргэжлийн зөвлөлийн 2022 оны 37 дугаар хурлаар хэлэлцүүлж хүлээн авсан.<br>- Сэлбэ дэд төвөөс Чингэлтэй дүүргийн 14, 18 дугаар хороо руу инженерийн дэд бүтцийн шугам сүлжээ татах ажлын зураг төсөл боловсруулах ажлын эхлэлийн тайланг Мэргэжлийн зөвлөлийн 2022 оны 39 дүгээр хурлаар хэлэлцүүлэн хүлээн авсан. Одоо дундын тайланд захиалагчийн хяналт тавин ажиллаж байна. | |
| | 2.2 | | 9.1.2. Хүн амын тооцоот нягтралаас хэтэрсэн байршлын судалгааг гаргаж, хүн ам, барилгажилтын нягтралыг хориглох бүсийг тогтооно. | 2022<br>2025 | | | 1 | 2 | - | - | Нийслэлийн иргэд, оршин суугчдын эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах зорилгоор "Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм БНбД 30.01.04"-д заасан хүн амын тооцоот нягтралын хязгаарыг давсан байршлуудад хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагаа, нийгмийн болон инженерийн дэд бүтцийн барилга байгууламж, зам, замын байгууламж, тохижилт, ногоон байгууламж, нийтийн эзэмшлийн зам талбай барихаас бусад зориулалтаар шинээр газар эзэмших, ашиглах, өмчлөх эрх олгох, шилжүүлэх, талбайн хэмжээ, зориулалт, эдэлбэрийн хэлбэр өөрчлөх, архитектур төлөвлөлтийн даалгавар, загвар зураг батлах, түүнд өөрчлөлт оруулах үйл ажиллагаа явуулахыг хориглох шийдвэр гаргуулах талаар Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 11 дүгээр | 100 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | сарын 10-ны өдрийн 19 дүгээр хуралдаанаар хэлэлцүүлэн “Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм” БНбД 30.01.04-д заасан хүн амын тооцоот нягтралын хязгаарыг давсан байршлуудыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барьж, хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн. Одоогоор Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. | |
| | 2.3 | | 9.1.3.Гэр хорооллыг хөгжүүлэх стратеги төлөвлөгөө боловсруулан, хэрэгжүүлсэн байна. | 2022 2025 | | | 1 | 2 | - | - | Хөрөнгө оруулалтын ажил шийдэгдээгүйн улмаас тус ажил хийгдэх нөхцөл бүрдээгүй байна. **Тайлбар:** Улаанбаатар хотод сөрөг нөлөө үзүүлж байгаа үйлдвэр, аж ахуйн нэгжийг хотоос шилжүүлэх бодлого боловсруулах ажлыг Нийслэлийн 2022 оны төсөвт тусгагдсан "Шинээр баригдах барилга байгууламж, авто зам, инженерийн шугам сүлжээний зураг төсөв, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, ТЭЗҮ, мастер төлөвлөгөө, зөвлөх үйлчилгээ" боловсруулах хөрөнгөөс шийдвэрлэх саналыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст 2022 оны 02/325 дугаартай албан бичгээр хүргүүлсэн боловч хөрөнгийн эх үүсвэр шийдвэрлэгдээгүй. Нийслэлийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд тусгуулж Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн 88 дугаар тогтоолоор батлуулав. | 30 |
| | 2.4 | 9.2. Төр захиргаа, мэдээлэл технологи, бизнес санхүү, соёл, | 9.2.1. "Яармаг" хотын шинэ төвийн ерөнхий төлөвлөгөө /Нисэх, | 2021 2025 | | 200.0 | - | 1 | | 76.9 | Нисэх, Яармаг орчмын орон сууцны хорооллын ерөнхий төлөвлөгөөний тодотгол боловсруулах ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын 2021 оны | 70 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | боловсрол, худалдаа үйлчилгээ, орон сууц, нийгмийн болон инженерийн дэд бүтцийн хангамж бүхий хотын шинэ төв, дэд төв, олон нийтийн төвүүдийг байгуулж, хотын хэт төвлөрлийг бууруулна. | Яармаг орчмын орон сууцны хорооллын ерөнхий төлөвлөгөөний тодотгол/ шинэчлэн боловсруулагдаж, төлөвлөлтийн дагуу бүтээн байгуулалт хэрэгжих боломжийг бүрдүүлсэн байна. | | | | | | | | А/651 дүгээр захирамжийн дагуу "27 дугаар нэгж хороолол"-ын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажилд захиалагчийн хяналт тавин ажиллаж байна.<br>Тус ажлын дундын тайланг Мэргэжлийн зөвлөлийн 2022 оны 35 дугаар хурлаар хэлэлцүүлж, төлөвлөлтийн шийдлийг дэмжсэн бөгөөд Байгаль орчин, аялал жуулчлалын яам, нутгийн захиргааны холбогдох байгууллагуудын саналыг тусган эцэслэн боловсруулахаар шийдвэрлэв. | |
| | 2.5 | 9.3. Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн үйл ажиллагаанд ухаалаг технологийг нэвтрүүлж, нийслэлийн хот байгуулалтын дундын мэдээллийн санг өргөжүүлэн, иргэд, олон нийтэд нээлттэй болгоно. | 9.3.1. Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд суурилсан газар олгох, барилга барих зөвшөөрлийг иргэд, олон нийтэд нээлттэй болгосон байна. | 2021<br>2025 | | | - | 1 | - | - | "Барилгын зөвшөөрөл олгох үйл ажиллагааг цахимжуулах" ажлыг Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2021 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуралд танилцуулсан ба 19 дүгээр хурлын тэмдэглэлээр уг ажлыг эрчимжүүлэх, хэрэглээнд нэвтрүүлэх үүрэг өгөгдсөн. Үүргийн дагуу нийслэлийн 2022 оны төсөвт тусгуулах саналыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/170 дугаар захирамжаар батлагдсан тус ажлын тендерийг Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас зохион байгуулж, шалгарсан "Смарт дата" ХХК-тай 2022 оны 05 дугаар сарын 09-ний өдөр гэрээ байгуулан хот байгуулалтын мэдээллийн сангийн одоогийн ашиглаж буй программ хангамж, үйл ажиллагааны процесс, шат дамжлагыг судалж, цаашид боловсруулах программ хангамжийн шийдэл гаргаж, Хот байгуулалтын мэдээллийн сангийн өгөгдөл хөрвүүлэлт, программ хангамжийн дотоод удирдлагын систем, үйлчилгээний | 100 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | хүсэлт, мэргэжлийн зөвлөлийн хурлын бүртгэл, архитектур төлөвлөлтийн даалгаврын модулийн хөгжүүлэлт, админ хэрэглэгчийн гарын авлага болон сервер суурилуулалтын ажлыг хийж гүйцэтгэв. Тус ажлын эхлэлийн тайлан, дундын тайланг хэлэлцүүлэн ХБМХ-2022/13, 2022/14 дүгээр актаар тус тус хүлээн авсан. Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/923 дугаар захирамжийн дагуу үлдэгдэл санхүүжилтийг 2023 онд олгохоор болсонтой холбогдуулан “Смарт дата” ХХК-тай байгуулсан гэрээг сунгах, нэмэлт гэрээ байгуулан 2023 оны 1 дүгээр улиралд хүлээж авахаар ажиллаж байна. | |
| | 2.6 | | 9.3.2. Улсын кадастрын мэдээллийн нэгдсэн системд холбогдож, хэрэглээнд нэвтрүүлэн, гудамж, зам талбай, үл хөдлөх эд хөрөнгийн хаягийг шинэчлэн, хэрэглээнд нэвтрүүлсэн байна. | 2021 2025 | | | 20 | 100 | - | - | ГЗБГЗЗГ-ын даргын 2020 оны А/29 дүгээр тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийн хүрээнд 5 удаагийн хамтарсан уулзалт зохион байгуулж, Хот байгуулалтын мэдээллийн менежментийн системийн бүтэц, өгөгдөл сангийн зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн.дундын серверт Хот байгуулалтын мэдээллийн сангийн суурь өгөгдлүүд болон хаяг дугаартай барилгын мэдээллийг байршуулсан.<br>Дундын серверт байршуулсан өгөгдөл мэдээллийг утуу.игЬап.ооу.тп цахим хуудсаар дамжуулан олон нийтэд нээлттэйгээр харуулахаар туршилтыг эхлүүлээд байна. Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/170 дугаар захирамжаар батлагдсан тус ажлын тендерийг Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас зохион байгуулж, шалгарсан “АйСиТи групп” ХК-тай гэрээ байгуулан ажлын даалгаврын дагуу нийслэлийн хаягийн мэдээллийн сангийн одоогийн ашиглаж байгаа программ | 100 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | хангамж, үйл ажиллагааны шат дамжлагыг судлах, нийслэлийн хаягийн мэдээллийн санг шинэчлэх, нэгдсэн стандартад шилжүүлэх системийн ерөнхий бүтэц, цар хүрээг тодорхойлж суурь судалгааны ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Мөн Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газартай уулзаж хаягийн мэдээлэл солилцох серверүүдийн техник, холболтын шийдлийг тодорхойлсон. Хаягийн суурь өгөгдөл болох байр зүйн зургийн хөрвүүлэлтийг хийж гүйцэтгэх мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулан ажлыг гүйцэтгэж байна. Тус байгууллага нь захиалагчийн хяналт тавин Мэргэжлийн зөвлөлийн 2022 оны 30А дугаар хурлаар хэлэлцүүлж, ХБМХ-2022/20 дугаар актаар эхлэлийн тайланг хүлээн авсан.<br>Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/923 дугаар захирамжийн дагуу үлдэгдэл санхүүжитийг 2023 онд олгохоор болсонтой холбогдуулан “АйСиТи групп” ХК-тай байгуулсан гэрээг 2022 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн ХНААГ/202212155-1 дугаартай зөвлөх үйлчилгээ үзүүлэх ажлын хугацааг сунгах нэмэлт гэрээ байгуулан 2023 оны 1 дүгээр улиралд хүлээж авахаар ажиллаж байна. | |
| | 2.7 | | 9.3.3. Нийслэлийн нутаг дэвсгэрийг том масштабын байр зүйн тоон зургаар бүрэн зурагжуулсан байна. | 2021<br>2025 | | | 0 | 50.000га | - | - | Нийслэлийн хөгжлийн 2023 оны төсвийн төлөвлөгөөнд тусгуулах саналыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 02/01/1250 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Хөрөнгө оруулалтын ажил шийдэгдээгүйн улмаас тус ажил хийгдэх нөхцөл бүрдээгүй байна. | 30 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2.8 | 9.8. Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барилгажуулж, нийтийн зориулалттай орон сууцыг засварлан иргэдийн эрүүл, аюулгүй таатай орчинд амьдрах эрхийг хангана. | 9.8.1. Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барилгажуулсан байна. | 2021<br>2025 | | | 27 | 13 | - | - | Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай 1175 өрхийн орон сууцны барилгыг буулган дахин төлөвлөн барилгажуулах, орон сууцыг орон сууцаар солих замаар чөлөөлөх, чөлөөлсөн талбайд түрээсийн орон сууцны төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, зохион байгуулах чиг үүргийн дагуу "Нийслэлийн Орон сууцны корпораци" ХК-д Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/498 дугаар захирамжаар шилжүүлж батлуулсан. Үүнд:<br>✓ Сонгинохайрхан дүүргийн 19 дүгээр хорооны нутаг дэвсгэр дэх 1-48, 2-48, 4-48, 3-20 дугаар байр,<br>✓ Баянзүрх дүүргийн 10 дугаар хорооны нутаг дэвсгэр дэх ХАА-27 дугаар байр,<br>✓ Сүхбаатар дүүргийн 10 дугаар хороо хорооны нутаг дэвсгэр дэх 1, 2, 3, 4, 6, 9, 10 дугаар байр.<br>Нийслэлийн ерөнхий архитектор ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламжийг дахин төлөвлөх барилгажуулах төсөл хэрэгжүүлэгчдээс ирсэн хүсэлтийн дагуу 6 байршилд архитектур төлөвлөлтийн даалгавар, (нийт 1734 өрхийн хүчин чадалтай) загвар зураг төсөл баталсан.<br>2022 онд 63 айлын 4 орон сууцыг буулган, 377 айл өрхийн орон сууц ашиглалтад орсон. Үүнд:<br>✓ Баянзүрх дүүргийн 16 дугаар хорооны нутаг дэвсгэр, төсөл хэрэгжүүлэгч "Металл энд Вүүд" ХХК нь Төмөр замын Ажилчдын 5 дугаар байр 12 айлын орон сууцыг буулгаж, 137 айлын үйлчилгээтэй орон сууцны барилга,<br>✓ Хан-Уул дүүргийн 2 дугаар хорооны нутаг дэвсгэр, төсөл хэрэгжүүлэгч "Эм | 70 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | Эм Жи Капитал" ХХК нь Нэхмэлийн 3 дугаар байр болох 27 айлын орон сууцыг буулгаж, 97 айлын үйлчилгээтэй орон сууцны барилга,<br>✓ Баянгол дүүргийн 5 дугаар хорооны нутаг дэвсгэр, төсөл хэрэгжүүлэгч "Тэргүүн Чансаа" ХХК нь Төмөр замын 9,10 дугаар байр 24 айлын орон сууцыг буулгаж, 143 айлын үйлчилгээтэй орон сууцны барилга, | |
| | 2.9 | 9.9. Хотын барилга байгууламжийг паспортжуулан, газар хөдлөлтөд тэсвэрлэх чадварт хянан баталгаажуулалт хийнэ. | 9.9.1. 2002 оноос өмнө баригдсан орон сууц болон олон нийтийн зориулалттай барилга, байгууламжийн бат бэх, найдваржилтын төлөв байдалд мэргэжлийн дүгнэлт гарган, паспортжуулах ажлыг хийж дууссан байна. | 2021 2025 | | 200,0 | 855 | 929 | - | - | Нийслэлийн Засаг даргын 2022 оны "Эрх шилжүүлэх тухай" А/171 дүгээр захирамж, Газрын даргын 2022 оны "Үнэлгээний хороо байгуулах тухай" А/04 дүгээр тушаалын дагуу 172 барилгын бат бэх, найдваржилтын төлөв байдалд мэргэжлийн дүгнэлт гарган, паспортжуулах 5 багц ажил тендерийг 2022 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 2 удаа зарлаж, 1 аж ахуйн нэгж үнийн санал ирүүлсэн боловч тендерийн баримт бичгийн иж бүрдэл дутуу, шаардлага хангаагүй учир тендер амжилтгүй болсон. Үнэлгээний хороо 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдөр хуралдаж, 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдөр 5 хоногийн хугацаатайгаар дахин сонгон шалгаруулалт зарлах тов гаргасан боловч, Нийслэлийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 01/2087 дугаар албан бичгийн дагуу төсвийн тодотгол хийж дуусах хүртэл сонгон шалгаруулалтыг түр хугацаагаар зогсоосон. Улмаар төсвийн тодотголоор хөрөнгө нь татагдсан.<br>2022 оны байдлаар 109 барилгад паспортжуулалтын мэргэжлийн дүгнэлт гаргав. Үүнд: | 70 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | - Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/378 дугаар захирамжийн хүрээнд он дамжин хэрэгжиж буй 73 барилга,<br>- УИХ-ын байнгын хорооны 2018 оны 07 дугаар тогтоол, Чингэлтэй дүүргийн 9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах 1952-1956 оны хооронд баригдсан Дэнжийн 1000-ын нийтийн зориулалттай 32 барилгад, Төрийн өмчийн аж ахуйн нэгжийн хүсэлтийн дагуу 4 барилга. | |
| | 2.10 | | 9.9.2. Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, олон нийтийн барилгын хүчитгэлийн зураг, гамшгийн эрсдэлд тэсвэртэй амины сууцны загвар зургийг боловсруулсан байна. | 2021 2025 | | | 5 | 10 | - | - | Нийслэлийн 2021, 2022 оны төсөвт Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, олон нийтийн барилгын хүчитгэлийн зураг боловсруулах ажилд хөрөнгө батлагдаагүй.<br>Монгол Улсын Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх чадавхыг бэхжүүлэх төслийн 2 дугаар үе шатны ажил эхлэхтэй холбоотой 2022 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр Япон Улсын хамтын ажиллагааны ЖАЙКА байгууллагын төлөөлөлтэй уулзаж, барилга байгууламжийг хүчитгэх эрх зүйн орчин, бодлого, норм дүрэм, хүчитгэх үйл ажиллагаа, боловсон хүчний чадавхыг бэхжүүлэх талаар санал солилцов. Тус уулзалтаар 5 барилгын хүчитгэлийн зураг боловсруулахаар болсон. Төсөл 2022-2026 онд хэрэгжинэ.<br>Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн 2022 оны 19 дүгээр хуралдаанд Нийслэлийн Ерөнхий архитектор барилга байгууламжийг паспортжуулах, хүчитгэх асуудлыг танилцуулсан. Тус хуралдаанаар “Барилга, байгууламжийг хүчитгэх, бэхлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх талаар журам боловсруулах” ажлын хэсэг байгуулах шийдвэр гарсан. | 70 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/554 дүгээр захирамжаар Гамшигт тэсвэртэй амины орон сууцны нэг маягийн 10 төрлийн загвар зураг боловсруулах ажилд 100 сая төгрөг батлагдсан. Сонгон шалгаруулалт зохион байгуулахад шаардлагатай Гамшигт тэсвэртэй амины орон сууцны нэг маягийн ажлын даалгаврыг боловсруулан Нийслэлийн Ерөнхий архитектороор батлуулан Нийслэлийн Худалдан авах, ажиллагааны газарт хүргүүлсэн. Нийслэлийн Худалдан, авах ажиллагааны газраас худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалт зарлаж, "Эм Эм Инженеринг" ХХК шалгарч 2022 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр 96.3 сая төгрөгийн өртөг бүхий гэрээ байгуулсан. Гэрээний дагуу "Эм Эм Инженеринг" ХХК зураг боловсруулж эхлэлийн тайланг 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн Мэргэжлийн зөвлөлийн хурлаар танилцуулж засвартайгаар тайланг хүлээн авахаар дэмжигдсэн. Эцсийн тайланг гэрээнд заасны дагуу 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр хүлээн авахаар ажиллаж байна. | |
| | 2.11 | 9.10. Эрчим хүчний ашиглалтын үр ашгийг өсгөж, дэд бүтцийг өргөжүүлэн, технологийн шинэчлэл хийж, хүн амыг тогтвортой эрчим хүчээр хангана. | 9.10.2. Эрчим хүчний цэнэг хураагуурын станц шинээр ашиглалтад оруулсан байна. | 2021 2025 | | | - | 1 | - | - | Азийн хөгжлийн банкны зээл болон буцалтгүй тусламжаар 220/110/35 кВ-ын Сонгино дэд станцыг түшиглэн эрчим хүчний сүлжээнд ашиглах 80 МВт/200 МВт.ц чадалтай том чадлын хуримтлуурын төслийг БНХАУ-ын ZTT болон ZEST компаниудын хамтарсан консорциум 2022-2025 онд хэрэгжүүлэхээр гэрээ байгуулагдав.<br>Зураг төслийн ажлыг эхлүүлэхээр төслийн талбайд Геодези болон Инженер-геологийн судалгааны | 30 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | ажлуудыг гүйцэтгэж дуусан ажлын зураг төсвийг боловсруулахаар судалгаа тооцооны ажил хийгдэж байна. | |
| | 2.12 | 9.12. Дулааны эрчим хүчний дотоодын хэрэгцээг бүрэн хангах эх үүсвэрийн чадлын нөөцийг бий болгоно. | 9.12.1. Дулааны станцын хүчин чадал, гол магистраль шугамын дулаан нэвтрүүлэх чадвар нэмэгдсэн байна. | 2021 2025 | | | - | - | - | - | - Сэлбэ дэд төвийн дулааны станц 2021 оны 4 дүгээр улиралд ашиглалтад орсон. Сэлбэ дулааны станцын 7МВт-ын 1 зуух ажиллагаанд залгагдсан бөгөөд 29 аж ахуйн нэгж байгууллага төвлөрсөн дулаан хангамжийн сүлжээнд холбогдсон.<br>- Налайх дүүрэг 180МВт-ийн дулааны станцын ажлын зураг төсөл хийгдэж дууссан, 2023 оны Улсын төсөвт барилга угсралтын ажлын хөрөнгө тусгуулахаар санал хүргүүлсэн.<br>- Дамбадаржаа дэд төвийн 63МВт-ын хатуу түлшний дулааны нх үүсвэрийн ТЭЗҮ, ажлын зураг төсөл бүрэн дууссан. Гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төслөөр хэрэгжихээр газар чөлөөлөлтийн ажил бүрэн хийгдсэн.<br>- Амгалангийн дулааны станцын өргөтгөлийн ажлыг концессын гэрээгээр гүйцэтгэхээр Эрчим хүчний яам гэрээ байгуулан ажиллаж байна. | 100 |
| | 2.13 | | 9.12.3. Хийн түлшний дулааны эх үүсвэрүүдийг барьж байгуулна. | 2021 2025 | | | - | 5 | - | - | Эрчим хүчний яамны Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн 2021 оны 5 дугаар хуралдааны 1 дүгээр хурлын тэмдэглэлээр Төвлөрсөн дулаан хангамжийн сүлжээтэй хосолмол ажиллагаатай 80 Гкал/цаг-ийн хийн түлшний дулааны эх үүсвэрийн ТЭЗҮ дэмжигдсэн. Тус станц нь Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хорооны нутагт 3,8 га нэгж талбарт төлөвлөгдсөн бөгөөд одоогоор газар чөлөөлөлт хийгдээгүй байна. */Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба хариуцна./* | 70 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2.14 | | 9.12.4. Төвлөрсөн дулаан хангамжид холбогдох боломжгүй аж ахуйн нэгж, байгууллагын хатуу түлшний халаалтын зуухнуудыг хийн түлшинд шилжүүлсэн байна. | 2021 2025 | | | 20 | 70 | - | - | - Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1322 дугаар захирамжаар Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах бүсэд түүхий нүүрс хэрэглэдэг халаалтын зуухыг буулгаж төвлөрсөн дулаан хангамжид холбох ажлын хөрөнгө шийдвэрлэгдсэн. Уг ажлын барилга угсралтын ажил дуусаж, улсын комисст хүлээлгэн өгсөн.Үүнд:<br>✓ Хан-Уул дүүргийн 5 дугаар хороо, 41-р сургууль, 29, 71-р цэцэрлэгийн барилга<br>✓ Баянзүрх дүүргийн 10-р хороо, ШШГЕГ-ын харьяа 421-р нээлттэй хорих ангийг төвлөрсөн дулаан, хүйтэн ус<br>✓ Баянзүрх дүүргийн 8, 16, 19-р хороо, Газарчин, Эрдэнэ-Толгой орчмын уурын зуухтай 21 айл өрх, аж ахуйн нэгж байгууллагуудыг төвлөрсөн дулаан хангамжийн сүлжээнд холбох;<br>✓ Сонгинохайрхан дүүргийн 2 дугаар хороонд байрлах 42 дугаар сургууль, 81 дүгээр цэцэрлэгийн барилга.<br>- Гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төслийн нэгжид Нийслэлийн СХД, СБД, БЗД-ийн 10 байршилд сургууль, цэцэрлэгийн барилгын халаалтын зуухыг шинэчлэн хийн түлш болон сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэртэй хосолмол ажиллагаатай ажиллах ажлын зургийн даалгавар батлуулж хүргүүлсэн. Тус ажлуудын ажлын зураг төслийг зөвшилцсөн. Үүнд:<br>✓ СХД-ийн 24 дүгээр хороо, 134-р сургууль<br>✓ СХД-ийн 28-р хороо, 640 хүүхдийн сургууль<br>✓ СХД-ийн 25-р хороо, 170-р цэцэрлэг | 70 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | ✓ СХД-ийн 25-р хороо, 104-р сургууль<br>✓ СХД-ийн 4-р хороо, 640 хүүхдийн сургууль<br>✓ СХД-ийн 11-р хороо, 129-р сургууль<br>✓ БЗД-ийн 11-р хороо, 79-р сургууль<br>✓ БЗД-ийн 11-р хороо, 126-р сургууль<br>✓ СБД-ийн 17-р хороо, 58-р сургууль<br>Нисэх, Яармаг орчмын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу хийн түлшний дулааны эх үүсвэр барих ТЭЗҮ боловсруулах зардлыг 2023 оны Улс, =нийслэлийн төсөвт тусгуулахаар 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 02/01/1250 дугаар албан бичгээр саналаа хүргүүлсэн. Хөрөнгө оруулалтын ажил шийдэгдээгүйн улмаас тус ажил хийгдэх нөхцөл бүрдээгүй байна. | |
| | 2.15 | 9.13. Мэдээлэл, холбооны электрон автомат станц, мэдээлэл холбооны нэгдсэн төвийн барилгуудыг холбож, нэгдсэн том сүлжээ үүсгэн, зохион байгуулалтыг сайжруулна. | 9.13.1. Мэдээлэл, холбооны нэгдсэн төвийн барилга, худаг сувагчлалын байгууламж шинээр барьж, мэдээлэл холбооны нэгдсэн сүлжээ бий болгосон байна. | 2021 2025 | | | - | - | - | - | - Баянхошуу дэд төв, Сэлбэ дэд төвийн мэдээлэл холбооны нэгдсэн төвийн барилга, 5,6 км худаг сувагчлалын байгууламжийг ГХХХОДХ төслийн хүрээнд гүйцэтгэн ашиглалтад оруулан “Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХК-д шилжүүлэн өгсөн.<br>- Нисэх, Яармаг орчмын мэдээлэл холбооны нэгдсэн төвийн барилга, худаг сувагчлалын байгууламжийн ажлын зураг төслийг нийслэлийн 2020 оны төсвөөр гүйцэтгэн дууссан. | 100 |
| | 2.16 | 9.14. Инженерийн бэлтгэл арга хэмжээний барилга байгууламжийг барьж, иргэдийг үер, усны аюулаас урьдчилан сэргийлэн, амьдрах орчныг сайжруулна. | 9.14.1. Инженерийн бэлтгэл арга хэмжээний баримт бичиг, зураг төсөл боловсруулсан байна. | 2021 2025 | | | - | 1 | - | - | Улсын төсвийн хөрөнгөөр хийгдэж буй Улаанбаатар хотын Инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөөний гүйцэтгэгчээр 2021 оны 05 дугаар сарын 06-ны өдөр Престиж инженеринг ХХК гэрээ байгуулсан. Зөвлөх компаний ирүүлсэн эцсийн тайланг Мэргэжлийн зөвлөлийн 45 дугаар хурлаар хэлэлцүүлэн хүлээн авсан. Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж ажиллаж байна. | 90 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2.17 | | 9.14.2. Үерийн хамгаалалтын далан, суваг, шугам сүлжээг шинээр барих болон өргөтгөн, шинэчилсэн байна. | 2021 2025 | | | - | - | - | - | Доод Өлзийтийн ам, Сонгино амралт, суурьшлын бүсийн Туул голын орчмын үерийн хамгаалалтын далангийн зураг төсөл, Төв цэвэрлэх байгууламжийн бохир ус Туул голд нийлдэг хэсгийн эргийн хамгаалалтын далангийн зураг төсөл нийт 4 байршилд 18.6 км үерийн хамгаалалтын сувгийн төлөвлөлтийн шийдэл зураг төслийг хянан зөвшилцсөн. Мөн 13 байршилд ажлын зураг төсөл, ажлын даалгавар боловсруулагдан Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн баталгаажуулж, холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.<br>Хөрсний ус доошлуулах шугам сүлжээг 2 байршилд 27,7 км шугам, борооны ус зайлуулах шугам, 16 байршилд 24,6 км, 13 байршилд 11,5 км үерийн хамгаалалтын сувгийн ажлын зураг зөвшилцөн мэдээллийн санд тусгасан.<br>Хан-Уул дүүргийн 8, 21 дүгээр хорооны Жаргалантын амны үерийн хамгаалалтын сувгийн ажлын зураг төсөл зөвшилцсөн бөгөөд барилга угсралтын ажил хийгдэж байна. Туул голын үерийн хамгаалалтын далан сувгийн засвар шинэчлэлтийн ажлын хөрөнгө шийдвэрлэгдсэн бөгөөд "Хайдродизайн прожект" ХХК ажлын зураг төсөл гүйцэтгэж байна. | 100 |
| | 2.18 | 9.15. Ус хангамжийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх болон усны алдагдлыг бууруулж, шугам доторлох төслийг үргэлжлүүлж дуусгана. | 9.15.1. Хотын баруун хэсэгт ус хангамжийн шинэ эх үүсвэр барьж, төв цэвэрлэх байгууламжийн хаягдал усыг гүн цэвэршүүлэн, дулаан, цахилгааны | 2021 2025 | | | 0 | 100 | - | - | АНУ-ын Мянганы сорилын сангийн буцалтгүй тусламжаар хийгдэх доод эх үүсвэрийн ус хангамжийн төслийн барилга байгууламж, шугам сүлжээний нарийвчилсан зураг төслийн ажлыг АНУ-ын "АЭКОМ" компани, үндэсний зөвлөх "Престиж инженеринг" ХХК хамтран гүйцэтгэж байна. Барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Олон Улсын нээлттэй тендерийг 2020 | 90 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
